



ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

ШҮҮХ ХУРАЛД ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧ ОРОЛЦОХ НЬ

2021

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Улаанбаатар хот

ТАВ. ШҮҮХ ХУРАЛД ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧ ОРОЛЦОХ НЬ

Судалгааг удирдсан:

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал
Хууль зүйн ухааны доктор Х.Эрдэм-Ундрах

Судалгааг хянасан:

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн
Эрдэмтэн нарийн бичгийн дарга
Хууль зүйн ухааны доктор С.Сүхбаатар

Судалгааг гүйцэтгэсэн:

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн
Эрдэм шинжилгээний ажилтан Р.Хатансайхан
Эрдэм шинжилгээний ажилтан Б.Дүүрэнжаргал
Эрдэм шинжилгээний ажилтан С.Мягмарсүрэн

X3YX

УДИРТГАЛ

Захиргааны хэргийн анхан шатны шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгчийг оролцуулах эрх зүйн үндсийг Монгол Улсын Үндсэн хуулийн тавин хоёрдугаар зүйлд “Анхан шатны шүүх хэрэг, маргааныг хамтран шийдвэрлэхдээ иргэдийн төлөөлөгчдийг оролцуулна” хэмээн заасан тусгасан. Түүнчлэн захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 73 дугаар зүйлд иргэдийн төлөөлөгчийг Захиргааны хэргийн анхан шатны шүүх хуралдаанд оролцуулах журмыг, 75 дугаар зүйлд захиргааны хэргийн анхан шатны шүүх хуралдаанд оролцож буй иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлыг тус тус тодорхойлсон байдаг. Тус хуулийн 73 дугаар зүйлд иргэдийн төлөөлөгчийг захиргааны хэргийн шүүх хуралдаан оролцуулах журмыг тодорхойлохдоо 2012 оны Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуулийг эш татсан байна.

Гэвч дээрх эш татсан хууль болох Шүүхийн иргэдийн төлөөлөгчдийн эрх зүйн байдлын тухай хуулийг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2014 оны 01 дүгээр тогтоолоор “шүүх бүрэлдэхүүнд иргэдийн төлөөлөгч оролцуулах” нь Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн хэмээн үзэж хүчингүй болгосон.

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 5.3-т “шүүх эрх мэдлийн байгууллагын тогтолцоог боловсронгуй болгож, хүний эрх, эрх чөлөөний баталгааг хангах чиглэлээр 5.3.2-т Шүүхийн иргэдийн төлөөлөгчдийн эрх зүйн байдлын тухай хуулийг шинэчлэн сайжруулна” гэж тусгасан. Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулна” гэж тус тус тусгасан.

Ийнхүү 2021 онд Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын Арван гуравдугаар бүлэгт Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлыг тусгаж, иргэд олон нийтийн хяналтыг нэмэгдүүлэх зорилгоор анхан шатны шүүх хэрэг, маргааныг хамтын зарчмаар шийдвэрлэхэд шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгч оролцох журмыг тодорхойлсон.

Иймд 2021 оны Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн иргэдийн төлөөлөгчийн талаарх зүйл заалтыг хэрэгжилтэд дүн шинжилгээ хийхийг зорилоо.

Судалгааны зорилт

Судалгааны хүрээнд дараах зорилтыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Иргэдийн төлөөлөгчийг шүүх хуралдаанд оролцуулах талаар Үндсэн хуулийн үзэл баримтлалыг тодруулах;
2. 2021 оны Монгол Улсын Шүүхийн тухай хуулийг 2020 өмнөх хуулийн зохицуулалттай харьцуулан судлах;
3. 2021 оны Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар боловсронгуй болгосон шүүхийн иргэдийн төлөөлөгчийн зохицуулалтын Захиргааны хэргийн анхан шатны шүүх дэх практикийг судлах зорилго тус тус дэвшүүллээ.

ХЗҮХ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙГ ШҮҮХ ХУРАЛДААНД ОРОЛЦУУЛАХ ТАЛААР ҮНДСЭН ХУУЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ, БА УЛАМЖЛАЛ ЧИГ ХАНДЛАГА

1.1. Монгол Улсын Үндсэн хуулийн иргэдийн төлөөлөгчийг шүүх хуралдаанд оролцуулах тухай үзэл баримтлал

1992 оны Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Анхан шатны шүүх хэрэг, маргааныг хамтран шийдвэрлэхдээ иргэдийн төлөөлөгчдийг хуульд заасан журмын дагуу оролцуулна” гэж хуульчилсан.¹ 1992 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн хуурцаг №26-д мөн өдрийн 12.12 минутаас 12.30 минутыг хураан үлдсэн байдаг. Энэ хэсэгт анхан шатны шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгчийг оролцуулах эрх зүйн зохицуулалтын талаар АИХ-ын 78 хувийн буюу 330 хүний ирцтэй хэлэлцсэн байна. Тодруулбал, Б.Чимид: 52 дугаар зүйлийн 2. Анхан шатны шүүх хэрэг, маргааныг хамтран шийдвэрлэхдээ Иргэдийн төлөөлөгчдийг хуульд заасан журмын дагуу оролцуулна; Ж.Уртнасан: 52 дугаар зүйлийн зүйлийн 2 дугаар заалтыг баталъя. 302 депутат буюу 90 хувь нь зөвшөөрч баталж байна. 10 хүн татгалзаж, 14 хүн түдгэлзэж байна. 339 депутат саналаа өгч байна хэмээн тэмдэглэн үлдээжээ.²

Энэ нь нэг талаас анхан шатны шүүх хэрэг, маргааныг хамтран шийдвэрлэхэд иргэдийн төлөөлөгч оролцуулах асуудлыг Үндсэн хуулийн түвшинд бэхжүүлсэн чухал заалт юм. Нөгөө талаас Монгол Улсын Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлд “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ” хэмээн заасантай уялдаа холбоотой. Ингэснээр шүүх иргэдийн төлөөлөгчийн оролцоотойгоор анхан шатны журмаар хэрэг, маргааныг шийдвэрлэж байгаа нь асуудалд бодитой, бүрэн дүүрэн, бүх талаас нь хандаж шударга шийдвэр гаргахад ач холбогдолтой юм.³

1.2. Шүүх хуралдаан дахь иргэдийн төлөөлөгчийн оролцооны түүхэн уламжлал

Манай Улс 1992 онд Үндсэн хуулиараа анхан шатны шүүх хэрэг, маргааныг хамтран шийдвэрлэхдээ иргэдийн төлөөлөгчдийг оролцуулах тухай ерөнхий байдлаар хуульчилсан. Харин иргэдийн төлөөлөгчийг шүүх хуралдаанд оролцуулах тусгайлсан журмыг хуулиар нарийвчлан зохицуулахаар үлдээжээ. Үүнээс үүдэн Монгол Улсын Үндсэн хууль батлагдсанаас хойш шүүхийн иргэдийн төлөөлөгчийн оролцоог хангах талаар нарийвчлан зохицуулсан хууль 3 удаа батлагдсан байна.

1 Монгол Улсын Үндсэн хууль, 1992, <https://legalinfo.mn/mn/detail/367>

2 Ж.Амарсанаа, Үндсэн хуулийн эхийг баригч I дэвтэр, 2019, 311 дэх тал.

3 Г.Совд, Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар, 2000, 222 дахь тал.

Хүснэгт 1. Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлыг тодорхойлсон хуулиуд

Д/д	Хуулийн нэр	Батлагдсан огноо
1	Монгол Улсын Шүүхийн тухай хууль	1993
2	Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хууль	2012
3	Монгол Улсын Шүүхийн тухай хууль	2021

1993 оны Шүүхийн тухай хууль

Уг хуулийн 16 дугаар зүйлд, хэрэг, маргааныг хамтран шийдвэрлэхэд иргэдийн төлөөлөгчийг оролцуулах, 17 дугаар зүйлд иргэдийн төлөөлөгчийг сонгох хэмээн 2 зүйл заалтаар иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлыг хуульчилжээ.⁴ Уг 1993 оны Шүүхийн тухай хуулийг 2002 оны 7 дугаар сарын 4-ны өдөр хүчингүй болгосон.

2002 оноос 2012 оныг хүртэлх 10 гаруй жилийн хугацаанд Монгол Улсын Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр, Монгол Улсын Шүүх эрх мэдлийн стратеги төлөвлөгөөнд тусгагдсан шүүхийн салбарын шинэчлэл, үйл ажиллагааг боловсронгуй болгох батлах ажил идэвхгүй үргэлжилсэн⁵. Судлаачид 2012 оны шүүхийн шинэтгэлийн өмнө шүүхийн иргэдийн төлөөлөгчийг практикт хэлбэрийн төдий байна хэмээн шүүмжилж ирсэн.⁶ Энэ ч утгаараа 2012 оныг хүртэл шүүгчийн иргэдийн төлөөлөгчийн талаар зохицуулалт хэт ерөнхий, хэлбэрийн шинжтэй, шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгчийг бэлгэдлийн төдий оролцуулдаг байжээ. Өөрөөр хэлбэл, 1993-2013 оныг хүртэл явж ирсэн хэлбэрийн төдий иргэдийн төлөөлөгчийн оролцоог халж, иргэдийн төлөөлөгч шүүхэд бодитойгоор оролцох эрх зүйн механизм бий болгох шаардлага үүссэн.

2012 оны Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хууль

2012 онд шүүхийн иргэдийн төлөөлөгчийн хэлбэрийн төдий, ач холбогдолгүй оролцоог арилгах, иргэдийн төлөөлөгчийн үр нөлөөг дээшлүүлэх үүднээс хууль тогтоомжийг шинэчилсэн. Тодруулбал, 2012 оны Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 1 дүгээр зүйлд “Энэ хуулийн зорилт нь шүүх эрх мэдлийн байгууллагад ил тод, нээлттэй байх зарчмыг бэхжүүлэх, шүүн таслах ажиллагаанд олон нийтийн зүгээс хяналт тавих тогтолцоог бий болгох зорилгоор шүүн таслах ажиллагаанд оролцож байгаа иргэдийн төлөөлөгчийг сонгон шалгаруулах, түүний үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлж, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино” гэж хуульчилсан. Үүнээс үзвэл 2012 оны Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуулиар иргэдийн төлөөлөгчийн эрх хэмжээ, оролцох механизм, зохион байгуулалтыг нарийвчлан зохицуулсан нь иргэдийн оролцоог баталгаажуулж, Үндсэн хуулийн үзэл санааг бодит утгаар хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой зүйл хэмээн тодотгосон.⁷

4 1993 оны Шүүхийн тухай хууль, <https://legalinfo.mn/mn/detail/7167>

5 Шүүхийн тогтолцоог өөрчлөх бодлогын шийдвэрийн хэрэгжилт, Төв аймгийн жишээн дээр, 2015, 56 дах тал.

6 Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн шийдвэр, 2014.01.08, Дугаар 1, 1 дэх тал.

7 Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн шийдвэр, 2014.01.08, Дугаар 1, 1 дэх тал.

2012 оны шүүхийн иргэдийн төлөөлөгчийн талаарх эрх зүйн зохицуулалтыг Ардчилсан институт хүний эрхийн газраас Монгол Улсын шүүхийн тогтолцоон дахь процессын эерэг үзүүлэлт гэж үзсэн. Монгол Улсын хууль тогтоогчид шүүхийн иргэдийн төлөөлөгч сонгон шалгаруулах ажиллагааг шударга, чадавхжуулах боломж олгосон, шүүн таслах ажиллагаанд оролцож буй иргэдийн төлөөлөгчийн эрх, үүргийг хангалттай тодорхойлсон болохыг цохон тэмдэглэсэн байна.⁸ Өөрөөр хэлбэл, 2012 оны Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хууль иргэдийн төлөөлөгчийн эрх хэмжээ, оролцох механизм, зохион байгуулалтыг нарийвчлан зохицуулснаараа иргэдийн оролцоог баталгаажуулахыг зорьсон хууль юм.

Тус хуулиар иргэдийг шүүх бүрэлдэхүүнд оролцуулахаар хуульчилсан байв. Гэвч 2014 онд Монгол Улсын Үндсэн хуулийн цэц Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хууль (2012)-ийг Үндсэн хууль зөрчсөн хэмээн үзсэн. Тодруулбал, тус хууль нь Үндсэн хуулийн 52 дугаар зүйлийг зөрчсөн хэмээн Үндсэн хуулийн цэц шийдвэрлэсэн.⁹ Цэцийн гол үндэслэл нь иргэн шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож болохгүй гэсэн Үндсэн хуулийн заалт байв. Цэцийн шийдвэрээс үүдэн шүүх хуралдаан дахь иргэдийн төлөөлөгчийн хэлбэрийн төдий оролцоо хэвээр үлдсэн.

1.3. 2021 оны Монгол Улсын Шүүхийн тухай хуульд тусгасан шүүхийн иргэдийн төлөөлөгчийн талаарх зохицуулалт

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 5.3-т “шүүх эрх мэдлийн байгууллагын тогтолцоог боловсронгуй болгож, хүний эрх, эрх чөлөөний баталгааг хангах чиглэлээр 5.3.2-т Шүүхийн иргэдийн төлөөлөгчдийн эрх зүйн байдлын тухай хуулийг шинэчлэн сайжруулна” гэж тусгасан. Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулна.” гэж тусгасан.

Ингэхдээ Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2014 оны 01 дүгээр тогтоолоор Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн гол агуулга буюу “шүүх бүрэлдэхүүнд иргэдийн төлөөлөгч оролцуулах” зохицуулалт нь Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн гэж үзэж, хүчингүй болгосноор энэхүү харилцааг тусгайлсан хуулиар зохицуулах ач холбогдол буурсныг анхаарах, иргэдийн төлөөлөгчийн гаргасан дүгнэлтийг шүүхийн шийдвэр гаргахад харгалзан үзэх, мөн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хуулиудад иргэдийн төлөөлөгчийн гаргасан шийдвэр дүгнэлт, санал зэргээр ялгаатай нэршилтэй байгаа нь практикт ойлгомжгүй байдал үүсгэж байгааг анхаарч нэр томъёог нэг мөр жигдлэх, иргэдийн төлөөлөгчийн оролцоог нэмэгдүүлэх, иргэдийн төлөөлөгчөөр сонгогдсон иргэнд албан томилолт, замын зардал зэргийг олгох эрх зүйн үндэслэлгүй байгаа тул холбогдох харилцааг сайжруулах шаардлагатай гэжээ.¹⁰

8 Opinion on the law of Mongolia on the legal status of citizen representatives of court trials, p.6

9 Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн шийдвэр, 2014.01.08, Дугаар 1, 2 дахь тал.

10 Шүүхийн тухай хуулийн үзэл баримтлал, 2 дахь тал.

Уг үндэслэл шаардлагын хүрээнд Шүүхийн тухай хуулийн Арван гуравдугаар бүлэгт шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлыг тусгаж, анхан шатны шүүх хэрэг, маргааныг хамтын зарчмаар шийдвэрлэхдээ шүүх хуралдаанд оролцох иргэдийн хяналтыг сайжруулах, оролцоо итгэлийг нэмэгдүүлэх, үр нөлөөг дээшлүүлэх үүднээс иргэдийн төлөөлөгчийн тоог нэмэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хуулиудад иргэдийн төлөөлөгчийн гаргасан шийдвэр ялгаатай нэрлэгдэж байгааг /дүгнэлт, санал/ нэг мөр болгох, иргэдийн төлөөлөгчийн хөлс олгох журамд албан томилолт, замын зардал зэрэг зохицуулалтыг нэмж боловсронгуй болгон тусгана гэжээ.¹¹

Улмаар 2021 оны Шүүхийн тухай хуулиар шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлыг Арван гуравдугаар бүлэгт хуульчилсан. Энэ нь Үндсэн хуулийн агуулгыг нарийвчлан хуульчилсан төдийгүй, 2012 оны Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн дэвшилттэй заалтыг уламжлан авсан. Тодруулбал, шүүхийн иргэдийн төлөөлөгч шүүх хуралдаанд оролцохдоо дүгнэлт гаргах бөгөөд уг дүгнэлтийг шүүгч харгалзан үзэх, шүүх бүрэлдэхүүн иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийн агуулгыг шүүхийн шийдвэрийн тодорхойлох хэсэгт бичиж, уг дүгнэлтийг талаарх үндэслэлээ үндэслэх хэсэгт тусгахаар хуульчилсан.¹² Энэ нь шүүхийн иргэдийн төлөөлөгчийн оролцоог нэмэгдүүлэхэд ач холбогдолтой. Хэрвээ шүүх бүрэлдэхүүн шүүхийн иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийн талаар үндэслэх хэсэгт тодорхой тусгаагүй бол шүүгчид сахилгын шийтгэл оногдуулахаар хуульчилсан нь шүүхийн иргэдийн төлөөлөгчийн оролцоо, дүгнэлттэй холбоотой заалтыг хэрэгжүүлэхэд түлхэц болсон заалт юм. Гэвч иргэдийн төлөөлөгч шүүх хуралдаанд ажиглагчийн байр сууринаас оролцох оролцоо хэвээр байна. Олон улсад иргэдийн төлөөлөгчийг шүүх бүрэлдэхүүнд оролцуулснаар иргэдийн шүүхэд оролцох оролцоо нэмэгдэж, шүүхийн үйл ажиллагааны нээлттэй, ил тод байх зарчим хангагдана хэмээн үздэг.

Дүгнэн үзвэл, 1992 оны Үндсэн хуулийн үзэл баримтлалын агуулга нь “иргэдийн төлөөлөгчдийн оролцоотойгоор анхан шатны журмаар хэрэг, маргааныг шийдвэрлэж байгаа нь асуудалд бодитой, бүрэн дүүрэн, бүх талаас нь хандаж шударга шийдвэр гаргах” байжээ. Гэвч 1993 оны Шүүхийн тухай хууль, 2002 оны Шүүхийн тухай хууль, 2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх тухай хууль, 2002 оны ИХШХШтХ, 2002 оны Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар нарийвчлан зохицуулаагүй улмаас иргэдийн төлөөлөгчийг оролцуулах зохицуулалт хэлбэрийн төдий явагдаж байжээ.

Шигтгээ 1.

Монгол улсад шударга шүүхийн тогтолцоог бүрдүүлэх иргэдийн оролцоо чухал. Тэр дундаа шүүн таслах ажиллагаанд оролцдог иргэдийн төлөөлөгчийн тогтолцоог бүрдүүлэх явдал чухал. Бидний алсыг харж байгаа зүйл бол иргэдийн төлөөлөгчийн санал, дүгнэлтийг шүүхийн шийдвэрт тусгах, тэр хүмүүсийн санаа бодлыг шүүх шийдвэр гаргахдаа харж үздэг, ер болж өгдөг бол шүүн таслах ажиллагаанд иргэдийн төлөөлөгчид маш чухал үүрэгтэй оролцдог бөгөөд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлдэг, энэ Монголын бас нэг ардчиллын шинэ үзэгдэл байхыг хүсэж байна. Тэр хэмжээнд хүрээгүй байгаа.

Харин 2012 онд Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуулийг баталснаар иргэдийн төлөөлөгчийн талаар нарийвчлан зохицуулсан

11 Мөн тэнд, 4 дэх тал.

12 Монгол Улсын Шүүхийн тухай хууль, 2021, <https://old.legalinfo.mn/law/details/16047>.

хуультай болсон. Энэ нь шүүхийн ил тод, нээлттэй байх зарчмыг бэхжүүлэх шүүх таслах ажиллагаанд олон нийтийн зүгээс хяналт тавих тогтолцоог бий болгох замаар шүүхэд итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх үндсэн агуулгатай.

2021 оны Шүүхийн тухай хуулийн шүүхийн иргэдийн төлөөлөгчид холбогдох эрх зүйн зохицуулалт нь захиргааны хэргийн анхан шатны шүүх хуралдаанд оролцож буй шүүхийн иргэдийн төлөөлөгчийн оролцоог нэмэгдүүлэх, цаашлаад иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийг шүүх бүрэлдэхүүн харгалзан үзэх боломжийг бий болгосон. Түүнчлэн захиргааны хэргийн анхан шатны шүүх хуралдааны бүрэлдэхүүн иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийг шүүхийн шийдвэрийн тодорхойлох хэсэгт бичиж, уг дүгнэлтийн талаарх үндэслэлээ үндэслэх хэсэгт тодорхой тусгана. Хэрвээ тусгаагүй бол шүүгчид сахилгын шийтгэл оногдуулах үндэслэл болохоор хуульчилснаар шүүхийн иргэдийн төлөөлөгчийн оролцоо, дүгнэлттэй холбоотой заалтыг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн. Гэвч иргэдийн төлөөлөгчийн оролцоо шүүх хуралдаан оролцох, дүгнэлт гаргах төдийгөөр хязгаарлагдаж байна.

1.4. Монгол Улсын шүүх засаглалд итгэх иргэдийн итгэл ба шүүхийн иргэдийн төлөөлөгч

Монгол Улсын хувьд шүүх хуралдаанд оролцож буй иргэдийн төлөөлөгч шүүх хуралдааны мэтгэлцэх болон нотлох баримт судлан, шинжлэх ажиллагаанд оролцохдоо өөрсдийн туршлага дээр тулгуурладаг, ингэснээр шүүхийн шийдвэрт тухайн нийгмийн нөхцөл байдлыг тусгаж, ардчилсан оролцоог сайжруулж, “хуульд иргэдийн дуу хоолойг хүргэдэг”¹³ байна. Иргэдийн төлөөлөгч шүүх хуралдаанд биечлэн байснаар шүүгч ёс зүйн алдаа гаргах, шийдвэр гаргахдаа нэг талыг баримтлахаас сэргийлэхэд тус болохын сацуу шүүхийн шийдвэр үндэслэлтэй ил тод болж шүүхийн үйлчилгээ иргэдэд ойртдог хэмээн үздэг.¹⁴

Шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгчийг оролцуулахын зорилго нь шүүхийн ил тод, нээлттэй байдал болон шүүхэд итгэх илтгэлийг нэмэгдүүлэх явдал юм. Монгол Улсын хувьд иргэдийн эрх зүйн мэдлэг дутмаг байдалтай холбоотойгоор “шүүх” гэдэг үгийг сонсмогц ямар нэгэн таагүй, сөрөг сэтгэгдэл төрөх, шүүх ажиллагаанд ямар нэгэн хэлбэрээр оролцохоос айх, төвөгшөөх, түүнээс аль болох хол байхыг хүсэх зэрэг буруу ойлголт түгээмэл байдаг.¹⁵ Энэ ч утгаараа шүүхэд иргэдийн итгэх итгэл шүүхийн ил тод, нээлттэй байдалтай хамааралтайгаар хувьсан өөрчлөгдөж байна.

Шигтгээ 2.

Шүүхийн шинэтгэлийн гол зорилго нь шүүхийн үйл ажиллагаа олон нийтэд ил тод нээлттэй байх юм. Иргэдийн төлөөлөгчийн механизм гэдэг бол нэг талаараа олны анхааралд татсанаас бусад хэргүүдэд ч гэсэн иргэдийн анхаарлыг татаж оролцуулах гэдгээрээ механизм болгож оруулж байгаа арга хэлбэр.

Тодруулбал, 2007 онд Сант Марал сангаас улсын хэмжээнд иргэдийн шүүхэд хандах хандлагын талаар хийсэн судалгаагаар Монголчуудын дөнгөж 28 хувь нь

13 Opinion on the law of mongolia on the legal status of citizen representatives of court trials, p.16.

14 Мөн тэнд.

15 Шүүхийн ерөнхий зөвлөл, Нээлттэй нийгэм форум, Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн гарын авлага, 7 дахь тал.

шүүхэд очвол асуудлаа шударгаар шийдүүлж чадна гэж итгэдэг гэжээ.¹⁶ Харин 2015 онд ШЕЗ-ийн захиалгаар хийлгэсэн “Шүүхэд итгэх иргэдийн итгэл” судалгаагаар нийт судалгаанд хамрагдагсдын 35 хувь нь шүүхэд итгэдэггүй гэсэн бөгөөд зарим аймагт энэ үзүүлэлт 50 хүртэл хувьтай гарчээ.¹⁷ Хамгийн сүүлд буюу 2017 оны 08 сард “Шүүхийн ерөнхий зөвлөл шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгээс хийсэн судалгаанаас үзвэл “шүүхийн үйлчилгээнд цахим инноваци нэвтэрсэн, шүүхийн шийдвэр нээлттэй, үйл, үйл ажиллагаа нь ил тод болсон гэдэгтэй иргэдийн олонх санал нийлжээ.¹⁸ Энэ ч утгаараа 2017 оны 08 сард шүүхээр үйлчлүүлсэн иргэдээс шүүх хэрэг, маргааныг шударгаар шийдвэрлэнэ гэдэгт хэр итгэж байна вэ? гэж асуухад 63.1 хувь нь шүүхдээ итгэнэ гэж шууд хариулжээ.¹⁹ Өөрөөр хэлбэл, www.shuukh.mn сайтад шүүхийн шийдвэрийг нээлттэй тавьдаг болсон, шүүх хуралдааны бичлэгийг нөхөж үзэх, иргэд шүүхийн байранд очиж үйлчлүүлэх орчин нөхцөлийг нээлттэй болгосон зэрэг нь иргэдийн шүүхэд итгэл итгэл нэмэгдэхэд нөлөөлжээ.²⁰

Дээрхээс шүүхийн ил тод, нээлттэй байдал нэмэгдэхийн хэрээр шүүхэд итгэх иргэдийн итгэл нэмэгдэж байгааг харж болно. Ялангуяа захиргааны шүүхийн үйл ажиллагаанд биеэр оролцох тоог нэмэгдүүлж, улмаар хэргийн үйл баримт, захиргааны үйл ажиллагаа үндэслэлтэй эсэхэд дүгнэлт гаргаж, шүүгч тухайн дүгнэлтийн талаар шүүхийн шийдвэртээ тусгах нь шүүхийн ил тод, нээлттэй байдал нэмэгдэх нэг хүчин зүйл мөн. Ингэснээр захиргааны шүүхээр үйлчлүүлэх иргэдийн итгэл нэмэгдэнэ.

16 Sumati L and Sergelen TS, “Trend Lines In Public Perception of Judicial Administration in Mongolia (Comparative Study Based on Nationwide Surveys 2001, 2003, 2005, 2007)” (Sant Maral 2007), http://pdf.usaid.gov/pdf_docs/PDACL250.pdf.

17 Шүүхэд итгэх иргэдийн итгэл судалгааны тайлан, Монгол Улсын шүүхийн ерөнхий зөвлөл, 2015.

18 Шүүхийн ерөнхий зөвлөл шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн, “шүүхэд итгэл иргэдийн илтгэл” социологийн судалгааны тайлан, 2017, 10 дахь тал.

19 Мөн тэнд, 11 дэх тал.

20 Шүүхийн ерөнхий зөвлөл шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн, “шүүхэд итгэл иргэдийн илтгэл” социологийн судалгааны тайлан, 2017, 10 дахь тал.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШҮҮХ ХУРАЛД ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧ ОРОЛЦОЖ БУЙ БАЙДАЛ

2.1. Захиргааны хэргийн шүүх хуралдаан иргэдийн төлөөлөгчийг оролцуулах хэрэгцээ, шаардлага

Захиргааны хэргийн шүүх бол нийтийн эрх зүйн субъект болох захиргааны байгууллага, албан тушаалтны хууль дээдлэн бэхжүүлж, хүний эрхийг хангаж байгаа эсэхийг иргэд, хуулийн этгээдийн нэхэмжлэлийн үндсэн дээр шалгаж, тэдгээр байгууллага, албан тушаалтны хууль бус акт, дур зоргийн үйл ажиллагаанаас хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээн тогтоох зорилго эрх мэдэл бүхий дагнасан шүүх мөн²¹ бөгөөд тус шүүхтэй холбогдсон харилцааг ЗХШХШТХ-иар тусгайлан зохицуулдаг.

Захиргааны хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлыг ЗХШХШТХ-д дараахь байдлаар тусгажээ.

Хүснэгт 2. ЗХШХШТХ-д иргэдийн төлөөлөгчийн талаар зохицуулсан байдал

№	Сонгосон зүйл, заалт	Зүйл, заалтын агуулга
1	73 дугаар зүйлийн 73.1 дэхь хэсэг	73.1.Шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгчийг Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасан журмын дагуу оролцуулна.
2	75 дугаар зүйлийн 75.2 дахь хэсэг	75.2.Иргэдийн төлөөлөгч нь хэрэг хянан шийдвэрлэхэд дараахь эрх эдэлж, үүрэг хүлээнэ: 75.2.1.шүүхийн байранд хэргийн материалтай танилцах, түүнээс тэмдэглэл хийх; 75.2.2.нотлох баримт шинжлэхэд оролцох; 75.2.3.хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч, гэрч, шинжээчид асуулт тавих; 75.2.4.нэмэлт нотлох баримт цуглуулах талаар хүсэлт гаргах; 75.2.5.хэргийн үйл баримт, захиргааны үйл ажиллагаа үндэслэлтэй эсэх талаар дүгнэлт гаргах; 75.2.6.өөрт нь итгэмжлэн мэдэгдсэн төр, байгууллага, хувь хүний нууцтай холбоотой асуудлыг задруулахгүй байх; 75.2.7.энэ хуульд заасан шүүх хуралдааны дэгийг сахин биелүүлэх.
3	75 дугаар зүйлийн 75.3 дахь хэсэг	75.3.Энэ хуулийн 75.2.5-д зааснаар хэргийн үйл баримт, захиргааны үйл ажиллагаа үндэслэлтэй эсэх талаар гаргасан иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийг шүүх хуралдаанд уншиж сонсоно.

Захиргааны хэргийн шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгчийн гүйцэтгэх үүргийг дурдвал:

- Шүүхийн хэлэлцүүлгийн үед иргэдийн төлөөлөгч нотлох баримт шинжлэн судлахад оролцох,
- хэргийн оролцогч тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч гэрч шинжээчид асуулт тавих,
- нэмэлт нотлох баримт цуглуулах талаар хүсэлт гаргах,
- хэргийн үйл баримт, хэргийн оролцогчийн гэм буруутай эсэх талаар дүгнэлт гаргах,
- шүүх хуралдааны дэгийг сахин биелүүлэх,

21 Б.Чимид, Үндсэн хуулийн үзэл баримтлал, УБ, 2017, 305 дах тал.

- хэргийн үйл баримт, хэргийн оролцогчийн гэм буруутай эсэхийн талаар гаргасан иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийг шүүх хуралдаанд уншиж сонсоно.²²

Ийнхүү иргэн, захиргааны хэргийн шүүх хуралдаанд орж хэрэг шийдвэрлэх нь шүүхийн ил тод, нээлттэй байх зарчимд бүрэн нийцэж, шүүхийн шүүн таслах ажиллагаанд олон нийтийн хяналтыг тогтоож, шүүхээс шударга шийдвэр гаргах үндсэн механизм болох учиртай.

Судлаач Б.Чимид “...Шударга шүүх байхын эрх зүйн үндэс нь шүүх эрх мэдлийн үндсэн зарчмууд бөгөөд... “анхан шатны шүүх хэрэг, маргааныг хамтран шийдвэрлэхдээ иргэдийн төлөөлөгчийг хуульд заасан журмын дагуу оролцуулах...”²³ нь шүүх эрх мэдлийн үндсэн зарчим хэмээн үзсэн байдаг.

Харин судлаач Х.Тэмүүжин шүүхийн шүүгчийн хараат бус байдлаар хамгаалагдсан шүүгчид гагцхүү хуульд захирагдан иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг ханган ажиллаж буйг харуулан иргэдийн итгэлийг бэхжүүлэх, нөгөө талаар шүүн таслах ажиллагааг хариуцлагажуулахад чухал ач холбогдолтой шударга ёсонд нийцсэн механизм бол иргэдийн төлөөлөгчийн шүүх бүрэлдэхүүн дэх оролцоо хэмээн дүгнэсэн нь бий.

2.2 Захиргааны хэргийн шүүхийн онцлог ба захиргааны хэргийн шүүх хуралдаанд оролцох иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдал

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа ИХШХШТХ, ЭХХШТХ болон ЗХШХШТХ-аар тус тус зохицуулж байна. Шүүхийн ерөнхий зөвлөлийн тайлангаас харахад иргэдийн төлөөлөгч оролцож байгаа тоогоороо Захиргааны хэргийн шүүх ямагт бага хувийг эзэлдэг талаар доорх хүснэгтэн мэдээллээс харж болно.

Хүснэгт 3. Шүүх хуралд иргэдийн төлөөлөгч оролцсон тоон мэдээ

Он	Нийт оролцсон иргэдийн төлөөлөгчийн тоо	Захиргааны шүүхэд оролцсон иргэдийн төлөөлөгчийн тоо	Иргэний шүүхэд оролцсон иргэдийн төлөөлөгчийн тоо	Эрүүгийн шүүхэд оролцсон иргэдийн төлөөлөгчийн тоо
2015	3368	161	978	1938
2016	4527	212	1795	2453
2017	2649	157	946	1506
2018	1855	203	859	763
2019	2037	171	987	847
2020	2066	176	782	1077

Захиргааны хэргийн шүүхийн онцлог нь төрийн нэрийн өмнөөс гэмт этгээдийг гэсгээн цээрлүүлэх, хоёр иргэний хоорондын маргааныг шийдэх уламжлалт шүүх ажиллагаанаас хальж засаг төрийн байгууллагын үйл ажиллагаанд гарсан гажуудлыг иргэн хүний эрх, ашиг сонирхлын үүднээс шүүн тунгааж зөрчигдсөн эрхийг нь сэргээх өөр чиглэлтэй байдагт оршдог.²⁴

22 Шүүхийн ерөнхий зөвлөл, Нээлттэй нийгэм форум, Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн гарын авлага, 27 дахь тал.

23 Б.Чимид, Хууль дээдлэх ёсыг хангадаг шударга шүүхийн үүрэг, Үндсэн хуульт ёс ба үндэсний эрх зүйн тогтолцоо олон улсын симпозиум II, 2009, 28 дах талд.

24 Б.Чимид, Үндсэн хуулийн үзэл баримтлал, УБ, 2004, 161 дэх талд

Захиргааны хэргийн шүүх болон иргэний хэргийн шүүхэд сүүлийн зургаан жилд иргэдийн төлөөлөгч оролцсон байдал нь харьцангуй ялгаатай байгаа нь дараах шалтгаантай байж болох юм. Иргэдийн төлөөлөгчийг оролцуулахаар заасан буюу шүүх бүрэлдэхүүнээр шийдвэрлэх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг ИХШХШТХ болон ЗХШХШТХ-д тусгасан байдлыг харьцуулан үзвэл:

Хүснэгт 4. Шүүх хэргийг бүрэлдэхүүнээр шийдвэрлэх ЗХШХШТХ болон ИХШХШТХ-ийн харьцуулалт

ЗХШХШТХ	ИХШХШТХ
74 дүгээр зүйл. Шүүх бүрэлдэхүүн 74.1.Захиргааны хэргийн шүүх дараах хэргийг гурван шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэнэ: 74.1.1.анхан шатны шүүхийн шийдвэрийг давж заалдах, эсхүл хяналтын шатны шүүхээс хүчингүй болгож, дахин хэлэлцүүлэхээр буцаасан; 74.1.2.захиргааны хэм хэмжээний акттай холбоотой; 74.1.3.тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөр шүүх бүрэлдэхүүнтэй шийдвэрлэхээр тогтоосон.	81 дүгээр зүйл. Шүүх бүрэлдэхүүн 81.1.Анхан шатны журмаар шүүгч дангаар хянан шийдвэрлэхээс бусад хэргийг 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэй хянан шийдвэрлэнэ. 82 дугаар зүйл. Шүүгч дангаар хянан шийдвэрлэх хэрэг, эрх зүйн маргаан 82.1. Шүүгч дор дурдсан хуулийн дараах зүйл, хэсэг, заалтад заасан хэрэг, эрх зүйн маргааныг дангаар хянан шийдвэрлэнэ: 82.1.1.Иргэний хуулийн 8.1.1; 8.1.3; 8.1.4; 8.1.6-8.1.8 дахь заалт; 82.1.2.хөдөлмөрийн эрх зүйн харилцаанаас үүссэн маргаан; 82.1.3.гэр бүлийн эрх зүйн харилцаанаас үүссэн маргаан; 82.1.4.тэтгэврийн харилцаанаас үүссэн маргаан; 82.1.5.тэтгэмжийн харилцаанаас үүссэн маргаан; 82.1.6.энэ хуулийн 74, 133 дугаар зүйл; 82.1.7.шүүх мөнгөн торгууль оногдуулахаар хуульд заасан; 82.1.8.бусад хуулиар шүүхэд харьяалуулсан хэрэг, эрх зүйн маргаан.

ЗХШХШТХ болон ИХШХШТХ-д зохицуулсан байдлыг харахад захиргааны хэргийн шүүхэд шүүх бүрэлдэхүүнтэй шийдвэрлэх тохиолдлыг нэрлэж өгсөн бол иргэний хэргийн шүүхэд дангаар шийдвэрлэх маргааныг хуульчлаад бусад маргааныг бүрэлдэхүүнтэйгээр шийдвэрлэнэ гэж зааж өгсөн. Ийнхүү ялгаатай байдлаар шүүхийн бүрэлдэхүүнээр шийдвэрлэх хэрэг маргааныг ангилсан нь шүүхийн харьяаллаас шалтгаалан иргэдийн төлөөлөгчийн оролцоонд нөлөөлж байж болох юм.

“Шүүн таслах ажиллагааны өмнөх уламжлалт хоёр хүрээнээс бүтцийн хувьд ч, процессын эрх зүйн хувьд ч үнэн хэрэгтээ гарч чадаагүй байна. Энэхүү бодит байдал нь олон түмэн шүүхийг гэмтнийг гэсгээн цээрлүүлдэг эсхүл эрх тэгш хоёр этгээдийн халз маргааныг тасалдаг бөгөөд эд мөнгө, эрх дархтай талд нь үйлчилдэг байгууллага мэтээр ойлгож үнэлэхэд хүргэж байна. Амьдралд олон маягаар гардаг боловч иргэн хүний хүчин мөхөстөж дарагдан нуугдмалаар өнгөрдөг захиргааны гэх хэрэг маргааны хянаж шүүдэг захиргааны шүүхийг, өөрөөр хэлбэл засаг захиргааны байгууллага, албан тушаалтны хууль бус ажиллагаанаас болж зөрчигдсөн эрхээ хамгаалуулахаар иргэдийн гаргасан гомдол, нэхэмжлэлийг хянан шийдвэрлэдэг тийм шүүхийн дэд тогтолцоог бий болгож төлөвшүүлэх явдал юм.”²⁵


Захиргааны хэргийн шүүхийн онцлог нь харилцан тэнцвэргүй талууд буюу нэг талд захиргааны байгууллага байдаг бол нөгөө талд иргэн оролцдог явдал юм. Үүнээс шалтгаалан захиргааны хэргийн шүүхийн шийдвэр нь эрх зүйн боловсролгүй бусад иргэдэд ойлгомжгүй, тодорхой бус санагдах нь түгээмэл байдаг талаар судалгаанд дурдсан байдаг.

25 Б.Чимид, Үндсэн хуулийн үзэл баримтлал, УБ, 2004, 159 дэх талд.

2.3. Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ

Шүүхийн шийдвэрийн цахим санд 2021 оны байдлаар захиргааны хэргийн анхан шатны шүүх иргэдийн төлөөлөгчдийг оролцуулан шийдвэрлэсэн нийт 27 шийдвэр байна. Үүнээс 23 шийдвэр нь Монгол Улсын Шүүхийн тухай хууль 2021 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш гарсан байна.²⁶ Эдгээрээс 13 шийдвэрт шүүхээс иргэдийн төлөөлөгчийн гаргасан дүгнэлтэд тайлбар хийсэн нь талаас илүү хувийг эзэлж байгаа нь нэг талаараа сайшаалтай. Гэвч шийдвэрийн агуулгыг үзэхэд шүүхийн иргэдийн төлөөлөгчид тийм ч хангалттай тайлбарыг өгөөгүй байна. Үүнээс үзэхэд иргэдийн төлөөлөгчийн гаргаж буй дүгнэлт нь ач холбогдолгүй, хэлбэрийн төдий байгааг анхаарч үзвэл зохистой байна.

График 1. Иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийг шүүхийн шийдвэрт тусгасан байдал



Шүүхэд оролцох иргэдийн төлөөлөгчтэй холбогдох харилцааг Монгол улсын Шүүхийн тухай хуулийн Арван гуравдугаар бүлэгт зохицуулсан бөгөөд 66 дугаар зүйлийн 66.7-д “Шүүх бүрэлдэхүүн иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийн агуулгыг шүүхийн шийдвэрийн тодорхойлох хэсэгт бичиж, уг дүгнэлтийн талаарх үндэслэх хэсэгт тодорхой тусгана.” гэж заасан. Тус хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш гаргасан шийдвэрүүдээс 18 шийдвэр нь шүүхийн шийдвэрийн тодорхойлох хэсэгт тусгасан бол 13 шийдвэр нь зөвхөн үндэслэх хэсэгтээ тайлбарласан байна.²⁷

ЗХШХШТХ-ийн 73 дугаар зүйлийн 73.1-д “Шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгчийг Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасан журмын дагуу оролцуулна” гэж заасан нь одоог хүртэл хүчин төгөлдөр бус хууль эшлэж оруулсан нь хууль зүйн техникийн хэлбэрийн алдаатай байна.

Rule of law буюу эрх зүйт төрийн агуулга нь “Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг хянах болсноор аль субъектын эрх зүйн акт давуу эрхтэй байх тухай маргаан үгүйсгэгдэж, ямар нэг дур зоргоос ангид, илүү дээд хүчин чадалтай, шударга ёсонд тулгуурласан хуулийн үндсэн дээр эрх зүйн аливаа хэрэг, маргааныг шийдвэрлэх ёстой” гэсэн байдаг.²⁸ Тиймээс эрх зүйн актууд “Rule of law”-д нийцсэн эсэх нь чухал ач холбогдолтой юм. Английн хуульч Альберт Дайси (1835-1922)-ийн үзсэнээр эрх зүйт төр гэдэгт хүний эрхэд хуулийн үндэс суурилсан байх ёстой ба бүгд хуулийн

26 Хавсралт 1-ээс дэлгэрэнгүй байдлаар үзнэ үү.

27 Хавсралт 1-ээс дэлгэрэнгүй байдлаар үзнэ үү.

28 Н.Лүндэндорж, Төрийн онол, УБ, 2008, 222 дахь талд.

өмнө тэгш байж шүүхээс тогтоогоогүй бол хэнийг ч гэм буруутайд тооцож болохгүй гэсэн зарчмуудыг хангасан байхыг шаарддаг.

Хууль зүйн техникийн хувьд юун түрүүнд агуулгын болон хэлбэрийн шаардлагыг хангасан тохиолдолд Rule of law-д нийцсэн гэж үзэх боломжтой нь дээрхээс харагдаж байна. Агуулгын шаардлага гэдэгт эрх зүйн акт байгалийн хууль болон үнэт зүйлсдээ нийцсэн эсэх, тухайн зохицуулах шаардлага бүхий нийгмийн харилцаанд хэр нийлэмжтэй эсэхийг ойлгодог. Хэлбэрийн шаардлагад гол агуулгад Л.Фуллерийн зарчим болон техникийн дүрмүүд багтдаг.

ХЭСЭГ

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ТАЛААРХ ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

3.1. Холимог шүүхийн тогтолцоо

Шүүн таслах ажиллагаанд иргэдийн төлөөлөгчийг оролцуулж байгаа шалтгаан нь улс орон бүрд ялгаатай байдаг. Зарим улс хариуцагч/шүүгдэгчийн үүргийг бэхжүүлэх зорилготой байдаг бол зарим нь шүүн таслах ажиллагааг явуулахдаа нээлттэй байх зарчмыг баримтлах, шүүх эрх мэдлийн хүрээнд авлигатай тэмцэж өрсөлдөхүйц чадварыг нэмэгдүүлэх, шүүхийн тогтолцоонд итгэл, дэмжлэг нэмэгдүүлэх болон хүнд суртлыг бууруулах зорилготой байдаг.²⁹ Мөн иргэдийн төлөөлөгчид төрийн эрх мэдэлд хяналт тавих хүчин зүйл болдог. Иргэдийн төлөөлөгчийг шүүхийн шийдвэр гаргах ажиллагаанд оролцуулснаар шүүхийн шийдвэрийг болон шүүх эрх мэдлийг бүхэлд нь хүчин төгөлдөржүүлж, хууль ёсны байдлыг хангадаг.³⁰

Дэлхийн зарим улс оронд гүйцэтгэх засаглалын нөлөөг (засгийн газар) шүүх дангаараа эсэргүүцэхэд хүндрэлтэй байдаг. Ийм улс орнуудад холимог шүүх дэх энгийн шүүгчид дээрх гүйцэтгэх засаглалын нөлөөг даван туулах арга зам болж, шүүгдэгчийг засгийн газрын нөлөөлөлд өртөхөөс хамгаална гэж үздэг. Энэ нь захиргааны хэргийн шүүхэд ч мөн хамааралтай байдаг. Өөрөөр хэлбэл, холимог тогтолцоо нь шүүх засаглалыг улс төрөөс ангид бие даасан байх, ардчилсан шийдвэр гаргах чиг хандлагыг бий болгодогдоороо онцлогтой.³¹

Холимог шүүх гэдэг нь шүүх хуралдаанд оролцож, хууль ёсны шийдвэр гаргадаг мэргэжлийн шүүгч болон энгийн шүүгчдээс бүрддэг тогтолцоо³² бөгөөд холимог шүүхийн гишүүд хамтран шүүхийн шийдвэрээ гаргадаг. Энгийн шүүгчид нь манай улсын иргэдийн төлөөлөгчтэй ижил буюу хуульч мэргэжлийн бус, энгийн иргэдийн төлөөлөл байдаг. Харьцуулсан эрх зүй судлал бусад улс оронд нийтлэг байдлаар шүүх ажиллагаан дахь иргэдийн оролцооны

- “jury” буюу тангарагтны шүүгчид,
- “lay judge” буюу мэргэжлийн бус шүүгч гэсэн хоёр загвар байгаа гэж үздэг.

Тангарагтны шүүх нь тодорхой тооны иргэд шүүгчийн оролцоогүй хэргийг үйл баримт буюу гэм буруугийн хувьд шийдвэрлэдэг бол мэргэжлийн бус шүүгч нь мэргэжлийн шүүгч нартай хамтран гэм буруугийн болон бусад асуудлаар шийдвэр гаргахад оролцдог ялгаатай.³³

Тодруулбал, шүүхийн захиргаанд иргэдийн оролцоог хангахыг зорьдог хэд хэдэн улс байдаг. Үүнд Америкийн Нэгдсэн Улс, Их Британи, Оросын Холбооны Улс, Испани, Гүрж зэрэг улсууд шүүх хуралдааны шийдвэрийг (jury) төлөөлөгчдийн шүүх буюу иргэдийн төлөөлөгчдөөр гаргуулдаг. Харин Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Хорват, Япон зэрэг улсууд шүүх хуралдааныг мэргэжлийн болон мэргэжлийн бус шүүгч нарын бүрэлдэхүүнтэй явуулдаг холимог шүүхийн тогтолцоотой байна.³⁴

29 Opinion on the law of Mongolia on the legal status of citizen representatives of court trials, p.5.

30 The theory and reality of lay judge in mixed tribunals, 1037-1038.

31 Chicago-Kent Law review, Ears of the deaf: The theory and reality of lay judges in mixed tribunal, p1037.

32 Мөн тэнд, p1032.

33 Үндсэн хуулийн цэцийн шийдвэр, 2 дахь тал.

34 Opinion on the law of mongolia on the legal status of citizen representatives of court trials, p.,16

Холимог шүүхийн үүрэг бол хууль, эрх зүйн шийдвэр гаргах үйл ажиллагаа байдаг тул хууль, эрх зүйн шийдвэр гаргахад шууд хамааралтай онцлог шинж чанарууд нь системтэй сургалт, байнгын дадлагаар олж авсан эрх зүйн боловсрол, хууль эрх зүйн шийдвэр гаргах туршлага юм. Мэргэжлийн шүүгчид нь хууль зүйн боловсрол эзэмшсэн, эрх зүйн асуудал шийдвэрлэх туршлагатай төрийн албан хаагчид байдаг бол энгийн шүүгчид нь хуулийн чиглэлээр системчилсэн сургалтад хамрагдаагүй хүмүүс байна. Мэргэжлийн шүүгчид ажил мэргэжлээрээ ахих тусам олон тооны хэргийг шийдвэрлэх бөгөөд ижил төстэй хэргийг төсөөтэй байдлаар буюу тууштай шийдвэрлэх хандлагатай байдаг. Харин энгийн шүүгчдийг оролцуулснаар хууль ёсны шийдвэр гаргах, өөрөөр хэлбэл, бодитоор хэргийг шийдэж, тухайн хэргийн онцлогт тохируулж хууль хэрэглэх боломжтой болдог.

3.2. Холимог шүүхийн тогтолцоон дахь энгийн шүүгчдийн оролцоо

Холимог шүүхийн нөхцөлд мэргэжлийн шүүгчид энгийн шүүгчээс илүү өндөр статустай, илүү чадварлаг гэж үнэлэгддэг. Түүнчлэн шүүхийн процесст энгийн шүүгчдээс олон удаа оролцож, хууль ёсны шийдвэр гаргахдаа бодитойгоор сайн ажиллах шаардлагатай. Энэ ч утгаараа холимог шүүхийн хуралдааныг зөвхөн мэргэжлийн шүүгч даргалдаг. Холимог шүүх ашигладаг бүх улс орны хувьд мэргэжлийн шүүгч шүүх хуралдааныг даргалах явдал ижил байдаг. Энэ ч утгаараа мэргэжлийн шүүгчид хэлэлцүүлэгт давамгайлж, тэдний дуу хоолой энгийн шүүгчдээс илүү хүчтэй байдаг. Өмгөөлөгчдийн авсан судалгаанаас үзвэл энгийн шүүгчид хэргийг шийдвэрлэхэд багахан хувь нэмэр оруулдаг буюу тэдний оруулсан хувь нэмрийн нөлөөлөл нь бага гэжээ³⁵.

Судалгаанаас үзэхэд мэргэжлийн шүүгчид энгийн мэргэжлийн шүүгчидтэй санал нийлэхгүй байх тохиолдол тун ховор байсан. Энэ нь энгийн шүүгчид шүүхийн шийдвэрт нөлөөлдөггүй гэсэн үг биш юм. Энгийн шүүгчидтэй хийсэн ярилцлагаас үзэхэд тэд бүгд өөрсдийгөө шүүхийн шийдвэрт тодорхой хэмжээгээр нөлөөлдөг гэжээ³⁶.

Хятадын холимог шүүхүүдийн дунд явуулсан судалгаагаар мэргэжлийн шүүгчдийн 80 гаруй хувь нь энгийн шүүгчид зөвхөн «хааяа» эсвэл «ховор» дуу хоолойгоо илэрхийлдэг гэж мэдээлсэн байна. Өөрөөр хэлбэл шүүгчид саналын зөрүүтэй байдлаа «хааяа» эсвэл «ховор» илэрхийлсэн байна. Үүнээс үүдэн мэргэжлийн болон энгийн шүүгчдийн хоорондын санал зөрөлдөөний давтамж харьцангуй бага, харин зөвшилцлийн хувь өндөр байдаг³⁷.

Холимог шүүхийн тогтолцоон дахь энгийн шүүгчийн оролцоог ОУ-ын судалгаанд үндэслэн дараах байдлаар дүгнэсэн байна.

- Польш Улсад хийсэн судалгаагаар мэргэжлийн бус шүүгч холимог шүүхийн тогтолцооны дагуу оролцох нь шүүхийн шийдвэрт олон нийтийн санаа бодол тусгагдаж, шүүгчийн үйл ажиллагааг сайжруулахад хувьд нэмэр оруулдаг гэж үздэг³⁸ бөгөөд нөгөө талаас шүүхийн шийдвэрт тусгасан үндэслэлийг ойлгомжтой байдалд мөн нөлөөлдөг.

35 Chicago-Kent Law review Ears of the deaf: The theory and reality of lay judges in mixed tribunal, p.1061.

36 Chicago-Kent Law review Ears of the deaf: The theory and reality of lay judges in mixed tribunal, p.1059.

37 Мөн тэнд.

38 Stanislaw pomorski, Comment, Lay judges in the polish criminal courts: A legal and empirical description, 7 Case w. Res. J. Int'L. 198 (1974-1975).

- Олон нийтийн ойлголтыг өөрчлөх замаар шүүхийн хууль ёсны байдлыг нэмэгдүүлэх нь шүүгчдийг цорын ганц үнэт зүйл гэж судлаачид үздэг³⁹.
- Хорват улсад хийсэн судалгаанаас үзэхэд⁴⁰ судалгаанд оролцогч шүүгчдийн 85 гаруй хувь нь холимог шүүгчийн тогтолцооны талаар эерэг дүгнэлттэй байсан бол прокурор, улсын өмгөөлөгчийн 50 гаруй хувь нь дэмжсэн буюу үр нөлөөтэй гэж үзсэн.
- Судлаач Боручка Арктова⁴¹ энгийн шүүгчид буюу иргэдийн төлөөлөл мэргэжлийн шүүгчийн гүйцэтгэдэг “мэргэжлийн” үүргийг нөхөж “нийгмийн” үүргийг гүйцэтгэдэг гэж үзсэн байна.

Дээрх судалгаануудаас үзэхэд холимог шүүхийн тогтолцоо нь давуу тал ихтэй, шүүхийн үйл ажиллагаанд төрийн болон иргэдийн төлөөлөл хамтран оролцож шийдвэр гаргаснаар тухайн шүүхийн шийдвэр “хэт нэг талыг барьсан” бус тэнцвэртэй байдлаар шийдвэрлэгддэг зэрэг ач холбогдолтой байна. Нөгөө талаас шүүхэд иргэдийн төлөөлөл оролцсоноор шүүхийн үйл ажиллагаанд тавих хяналт болдог байна. Холимог шүүхийн тогтолцоогоор энгийн шүүгч болон мэргэжлийн шүүгчийн шийдвэр гаргах ажиллагаанд хүлээх үүрэг нь харилцан адилгүй байх бөгөөд харилцан бие биенээ нөхөх үүрэгтэй байна.

Өөрөөр хэлбэл иргэд шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгчөөр оролцож, өөрийн оролцоог шүүхийн захиргаанд хүргэснээр тэдний эрх зүйн мэдлэг дээшлэхээс гадна шүүн таслах ажиллагаанд иргэдийн оролцоо, хяналтыг бий болгох, шүүхийн үйл ажиллагаа олон нийтэд ил тод, нээлттэй болох, улмаар иргэдийн итгэлийг хүлээсэн үр нөлөөтэй, хариуцлагатай шүүхийн тогтолцоо бүрдэхийн зэрэгцээ шударга ёсыг тогтооход ихээхэн ач холбогдолтой юм.

3.3. Холимог шүүхийн тогтолцоог Монгол Улсын шүүхийн тогтолцоотой харьцуулах нь

Монгол Улсын шүүхийн тогтолцоо нь олон улсад буй холимог шүүхийн тогтолцооны алинд ч хамаарахгүй. Тодруулбал, манай улсын хувьд шүүхийн иргэдийн төлөөлөгч шүүх хуралдаанд оролцохдоо тухайн хэргийн үйл баримт шүүгдэгч буюу зохигчийн гэм буруугийн талаар дүгнэлт өгөх шүүх хуралдааны оролцогч байдгаараа онцлогтой.⁴² Өөрөөр хэлбэл, манай улсын хувьд шүүхийн иргэдийн төлөөлөгч нь хяналтын чиг үүргийг хэрэгжүүлдэг болохоос биш хэргийн бусад оролцогч болох хэргийн оролцогч, тэдгээрийн итгэмжлэгдсэн төлөөлөгч, өмгөөлөгч, гэрч, гуравдагч этгээдээс хэрхэн ялгах нь тодорхойгүй.⁴³ Харин холимог тогтолцоо нь шүүхийн иргэдийн төлөөлөгч шүүх бүрэлдэхүүнд ордог учир хэргийн оролцогчоос ялгаатай. Шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгчийг оролцуулах нь 1. Шүүхийн тогтолцоонд иргэдийн итгэл нэмэгдэх болон шүүхийн хүнд суртлыг бууруулах, 2. Шүүхийн шийдвэр болон шүүх эрх мэдлийн хууль ёсны байдлыг хангах, 3. Шүүхийн ил тод нээлттэй байдлыг хангах, шүүхийн үйлчилгээ иргэдэд ойртох зэрэг давуу талтай юм.

39 Chicago keny law review, “Ears of the deaf: The theory and reality of lay judges in mixed tribunals”, p.1062.

40 Мөн тэнд, p.1063.

41 Мөн тэнд, p.1065.

42 Мөн тэнд, 5 дахь тал.

43 Opinion on the law of Mongolia on the legal status of citizen representatives of court trials, p.14.

Шигтгээ 3

Шүүгч хүн, хуульч хүн хэрэг маргааныг дангаар шийдэхээр зөвхөн хуульд юу гэж заасан тэр үүднээс шийддэг. Хууль гэдэг маань дандаа шударга ёсны шалгуур байна гэдэг ойлголт дэлхийд байхгүй. Энэ учир дутагдлыг юугаар нөхдөг вэ гэхээр ямар ч хуулийн мэдлэггүй зөвхөн тэр хүний толгойд шударга ёсны мэдрэмж байгааг иргэдийг оруулаад, иргэдийн шударга ёсны мэдрэмжээр тэр шүүн таслах үйл ажиллагаа чимэж оруулах нь хуульд тусгагдаж чадаагүй шударга ёсны элемент шүүн таслах үйл ажиллагаанд оролцоно гэдэг дэлхийн чиг хандлага байдаг. Энэ чиг хандлага манай улсад дутагдаж байна. Үүнийг засах шаардлагатай. –судлаач Н.Лүндэндорж

ДҮГНЭЛТ, САНАЛ

Шүүн таслах ажиллагаанд иргэдийг оролцуулж байгаа шалтгаан нь улс орон бүрд ялгаатай байдаг. Уг шалтгаанд дараах нөхцөл байдлууд хамаарна:

1. Шүүхэд иргэдийн итгэл нэмэгдэх болон шүүхийн хүнд суртлыг бууруулах,
2. Шүүхийн шийдвэр болон шүүх эрх мэдлийн хууль ёсны байдлыг хангах,
3. Шүүхийн ил тод нээлттэй байдлыг хангах, шүүхийн үйлчилгээг ойртуулах.

Шүүн таслах ажиллагаанд иргэдийн оролцоог хангахыг зорьдог хэд хэдэн улс байдаг. Үүнд Америкийн Нэгдсэн Улс, Их Британи, Оросын Холбооны Улс, Испани Гүрж зэрэг улсууд шүүх хуралдааны шийдвэрийг (jury) тангарагтны буюу иргэдийн төлөөлөгчдөөр гаргуулдаг. Харин Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Хорват, Япон зэрэг улсууд шүүх хуралдааныг мэргэжлийн болон мэргэжлийн бус шүүгч нарын бүрэлдэхүүнтэй явуулдаг холимог шүүхийн тогтолцоотой байна.

Холимог шүүхийн тогтолцоонд мэргэжлийн шүүгчид энгийн шүүгчээс илүү өндөр статустай, илүү чадварлаг гэж үнэлэгддэг, илүү олон удаа оролцож, хууль ёсны шийдвэр гаргахдаа бодитойгоор илүү сайн ажилладаг. Энэ ч утгаараа шүүхэд итгэх итгэлийг нэмэгдүүлдэг.

Монгол Улсын хувьд дээрх хоёр тогтолцооны алинд ч хамаарахгүй. Өөрөөр хэлбэл, манай улсын хувьд шүүхийн иргэдийн төлөөлөгч шүүх хуралдаанд оролцохдоо тухайн хэргийн үйл баримт шүүгдэгч буюу зохигчийн гэм буруугийн талаар дүгнэлт өгөх шүүх хуралдааны оролцогч байдгаараа онцлогтой. Харин иргэдийн төлөөлөгч нь хяналтын чиг үүргийг хэрэгжүүлдэг болохоос биш хэргийн бусад оролцогч болох хэргийн оролцогч, тэдгээрийн итгэмжлэгдсэн төлөөлөгч, өмгөөлөгч, гэрч, гуравдагч этгээдээс юугаараа ялгаатай нь тодорхойгүй байдаг. Энэ ч утгаараа иргэдийн төлөөлөгч оролцоо хэлбэрийн төдий байдаг.

1992 оны Үндсэн хуулийн үзэл баримтлалын агуулга нь “иргэдийн төлөөлөгчдийн оролцоотойгоор анхан шатны журмаар хэрэг, маргааныг шийдвэрлэх замаар асуудалд бодитой, бүрэн дүүрэн, бүх талаас нь хандаж шударга шийдвэр гаргах” байжээ.

Харин 2021 оны Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн Шүүхийн иргэдийн төлөөлөгчид холбогдох зүйл заалт нь захиргааны хэргийн анхан шатны шүүх хуралдаанд оролцож буй шүүхийн иргэдийн төлөөлөгчийн оролцоог нэмэгдүүлэх, цаашлаад иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийг шүүх бүрэлдэхүүн харгалзан үзэх боломжийг бий болгосон. Үүний дагуу захиргааны хэргийн анхан шатны шүүх хуралдааны бүрэлдэхүүн иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийг шүүхийн шийдвэрийн тодорхойлох хэсэгт бичиж, уг дүгнэлтийн талаарх үндэслэлээ үндэслэх хэсэгт тодорхой тусгана. Хэрвээ тусгаагүй бол шүүгчид сахилгын шийтгэл оногдуулах үндэслэл болохоор хуульчилснаар шүүхийн иргэдийн төлөөлөгчийн оролцоо, дүгнэлттэй холбоотой заалтыг хэрэгжүүлэх нөхцлийг бүрдүүлсэн.

Монгол Улсын Шүүхийн тухай хууль 2021 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш захиргааны хэргийн шүүх 23 шийдвэр гарсан. Эдгээрээс 13 шийдвэрт шүүхээс иргэдийн төлөөлөгчөөс гаргасан дүгнэлтэд тайлбар хийсэн. Гэвч шийдвэрийн агуулгыг үзэхэд хангалттай тайлбарыг шүүхийн иргэдийн төлөөлөгчид өгөөгүй байна. Тодруулбал, Шүүхийн тухай хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш гаргасан 23 шийдвэрээс 18 шийдвэр буюу 78 хувьд иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийг шүүхийн шийдвэрийн тодорхойлох хэсэгт

тусгасан. Харин 13 шийдвэр буюу 56 хувьд иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийг үндэслэх хэсэгтээ тайлбарласан байна.

Үүнээс Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 66 дугаар зүйлийн 66.7-д “Шүүх бүрэлдэхүүн иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийн агуулгыг шүүхийн шийдвэрийн тодорхойлох хэсэгт бичиж, уг дүгнэлтийн талаарх үндэслэх хэсэгт тодорхой тусгана” гэж заасан зүйл заалт хэрэгжиж байна. Гэвч цаашид захиргааны хэргийн шүүх иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийг шүүхийн шийдвэрийг тодорхойлох хэсэгт дэлгэрэнгүй бичих улмаар уг дүгнэлтийг хүлээж авах эсэхээ үндэслэл хэсэгт дэлгэрэнгүй тайлбарлах шаардлагатай. Энэ нь захиргааны хэргийн шүүхэд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, ач холбогдлыг дээшлүүлнэ.

Иймд дараах саналыг дэвшүүлж байна:

1. ЗХШХШТХ-ийн 73 дугаар зүйлийн 73.1-д “Шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгчийг Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасан журмын дагуу оролцуулна” гэж заасан. 2021 онд Шүүхийн тухай хууль батлагдсанаар ЗХШХШТХ-ийн 73 дугаар зүйлд эш татсан “Шүүхийн иргэдийн төлөөлөгчдийн эрх зүйн байдлын тухай хууль” нь хүчингүй болсон байна. Гэвч ЗХШХШТХ-д хүчингүй болсон “Шүүхийн иргэдийн төлөөлөгчдийн эрх зүйн байдлын тухай хууль”-ийг эш татсан хэвээр байна. Үүнээс үүдэн ЗХШХШТХ-ийн иргэдийн төлөөлөгчийн тухай зохицуулалтад 2021 оны Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн үйлчлэл хамаарахгүй мэт харагдаж байна. Иймд ЗХШХШТХ-ийн 73 дугаар зүйлд заасныг хүчингүй болгох;
2. ЗХШХШТХ-ийн иргэдийн төлөөлөгчийн талаарх зохицуулалт нь Монгол Улсын Шүүхийн тухай хуульд хамаарч байгаа тул тус хуулийг ЗХШХШТХ-д эш татах;
3. 2021 оны 03 дугаар сараас Монгол Улсын Шүүхийн тухай хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн талаар дээр дурдсан билээ. Уг хуулийн 66 дугаар зүйлийн 66.7 дахь хэсэгт “Шүүх бүрэлдэхүүн иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийн агуулгыг шүүхийн шийдвэрийн тодорхойлох хэсэгт бичиж, уг дүгнэлтийн талаарх үндэслэх хэсэгт тодорхой тусгана” хэмээн заасан. Шүүхийн шийдвэрүүдэд хийсэн судалгаагаар 14 шийдвэр нь шүүхийн шийдвэрийн тодорхойлох хэсэгт тусгасан бол 6 шийдвэр зөвхөн үндэслэх хэсэгтээ тайлбарласан байна. Өөрөөр хэлбэл, оролцоо хэлбэрийн төдий буюу шүүхийн шийдвэрт иргэдийн төлөөлөгчөөс гаргасан дүгнэлтийг үндэслэх хэсэгт тодорхой тусгахгүй байгааг анхаарч, хуулийн хэрэгжилтийг хангах арга хэмжээг авч, шүүхийн шийдвэрт иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийг тодорхой тусгах зэрэг саналыг гаргаж байна.

НОМ ЗҮЙ

А. Хууль тогтоомж, эрх зүйн баримт бичиг

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он, <https://legalinfo.mn/mn/detail/367>
2. Шүүхийн тухай хууль 1993 он, <https://legalinfo.mn/mn/detail/7167>
3. Шүүхийн тухай хууль 2002 он, <https://legalinfo.mn/mn/detail/90>
4. Эрүүгийн байцаан шийтгэх хууль, 2002 он, <https://legalinfo.mn/mn/detail/59>
5. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2002 он, <https://legalinfo.mn/mn/detail/302>
6. Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн шийдвэр, 2014.01.08, Дугаар 1,
7. Шүүхийн тухай хуулийн үзэл баримтлал, <https://mglbar.mn/storage/files/u8aGyWpcxKotpqAJ9s64zYxQIWVdkSBEdVEBUqYP.pdf>
8. Монгол Улсын Шүүхийн тухай хууль, 2020 он, <https://old.legalinfo.mn/law/details/16047>

Б. Ном сурах бичиг, гарын авлага

1. Ж.Амарсанаа, Үндсэн хуулийн эхийг баригч I дэвтэр, хоёр дахь хэвлэлт, (УБ, 2019),
2. Г.Давааням нар, Монгол Улсын шүүх эрх мэдэл дэх иргэдийн оролцооны тогтолцоо, үндсэн хуулийг тайлбарлах асуудлын хүрээнд, (УБ, 2013)
3. Н.Лүндэндорж., Төрийн онол., (УБ., 2008),
4. Г.Совд, Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар, (УБ 2000),
5. Д.Хуяг “ИХШХШ эрх зүйн үндсэн болон тулгамдсан асуудлууд”. (УБ, 2013)
6. Б.Чимид “Хууль дээдлэх ёсыг хангадаг шударга шүүхийн үүрэг” үндсэн хуульт ёс ба үндэсний эрх зүйн тогтолцоо олон улсын симпозиум II. (УБ, 2009),
7. Б.Чимид “Үндсэн хуулийн үзэл баримтлал”. (УБ, 2004),
8. Б.Чимид, Үндсэн хуулийн үзэл баримтлал, (УБ, 2017),
9. А.Эрдэнэцогт, Монгол Улсын Захиргааны процессын эрх зүй, (УБ,2014),
- 10.“Шүүхэд итгэх иргэдийн итгэл судалгааны тайлан” Монгол Улсын шүүхийн ерөнхий зөвлөл, (УБ,2015),
- 11.Шүүхийн тогтолцоог өөрчлөх бодлогын шийдвэрийн хэрэгжилт, Төв аймгийн жишээн дээр, (УБ,2015),
- 12.Шүүхийн ерөнхий зөвлөл шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн, “Шүүхэд итгэл иргэдийн итгэл” социологийн судалгааны тайлан, (УБ, 2017),
- 13.Opinion on the law of Mongolia on the legal status of citizen representatives of court trials, (Warsaw,2019)
- 14.Шүүхийн ерөнхий зөвлөл, Нээлттэй нийгэм форум, Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн гарын авлага
- 15.Chicago-Kent law review, Ears of the deaf: the theory and reality of lay judges in mixed tribunal, (2015)
- 16.Stainslaw Pomorski, Lay judges in the polish crimuna courts: a legal and empirical description, (1974)

17. Sumati L and Sergelen TS., "Trend Lines In Public Perception of Judicial Administration in Mongolia (Comparative Study Based on Nationwide Surveys 2001, 2003, 2005, 2007)" (Sant Maral 2007), http://pdf.usaid.gov/pdf_docs/PDACL250.pdf.

ХЭЛЭН

Хавсралт 1. Захираганы хэгийн анхан шатны шүүхээр 2021 онд иргэдийн төлөөлөгч оролцож шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр

№	Нэхэмжлэлийн шаардлага	Нэхэмжлэгч	Хариуцагч	Иргэдийн төлөөлөгч оролцсон эсэх	Иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийн агуулгыг тусгасан эсэх/ Шүүхийн шийдвэрийн тодорхойлох хэсэгт дурьдсан эсэх	Шийдвэрийн дугаар, огноо	Иргэдийн төлөөлөгч дүгнэлтийн талаарх үндэслэлээ үндэслэх хэсэгт тодорхой тусгасан эсэх
1	"Үндэсний Аудитын газрын Санхүүгийн Аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, аудитор Ц.Энхжаргал, гэрээт аудитор М.Алтанхорол нарын 2019 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 01/80 САГ-2019/17/СТА-ЗГТС тоот актын Б.Э-нд холбогдох хэсгийг хүчингүй болгуулах"	Б.Э	Үндэсний Аудитын газрын Санхүүгийн Аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, аудитор Ц.Энхжаргал, гэрээт аудитор М.Алтанхорол	П.Отгонжаргал	Үгүй	128/ ШШ2021/0426 2021.06.16	Үгүй
2	"Төв аймгийн Б сумын 2020 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 85 дугаар хариу хүргүүлэх тухай албан бичгээр ашиглагдаагүй талбай дээрх газар эзэмших эрхийг дуусгавар болгох боломжгүй гэсэн хариуг ЗХШШГХ хуулийн 106.3.1-д заасны дагуу хууль бус болохыг тогтоож, хүчингүй болгуулах,	"ЦМЭЭ" ХХК	Төв аймгийн Б сумын Засаг дарга	Б.Энхбаяр	"Нэхэмжлэгч хариуцагч хоорондоо зөвшилцөөд болох юм байна"	123/ ШШ2021/0032 2021.09.22	Иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтээс, нэхэмжлэгч нар нэхэмжлэлийн шаардлагын үндэслэлдээ газрын төлбөрийн асуудлыг хөндөн тайлбар хийсэн боловч маргааны үндэслэл болгож буй хариуцагч Засаг дарга нарт гаргасан хүсэлтийг энэ асуудлаар тодорхой гаргаагүй байхад, харин ирээдүйд үндэслэлгүйгээр газрын төлбөр нэхэмжилж хууль ёсны эрхийг зөрчих үр дагавар үүсгэж байна гэж дурдсан нь нэхэмжлэгч нарын өөрсдийнх нь газар эзэмших эрхийн гэрээний зүйлийг өөрчлөх, зөвтгөх шүүд үндэслэлгүй юм.

3	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн 2014 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 07 дугаар тогтоол болон 2014 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн 56 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болгуулах	Ш.Б, М.Э	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	Н.Т нар	Үгүй	128/ шш2021/0592 2021.09.15	Үгүй
4	БОАХЯ-ны дүгнэлт, Ашигт малтмал газрын тосны газрын кадастрын хэлтсийн даргын шийдвэрийг тус тус хүчингүй болгуулах	Бат дөрвөн мөрөн ХХК	БОАХЯ, Ашигт малтмалын	Б.Солонго	"Нэхэмжлэгчийн талаас гаргасан шаардлагыг үндэслэлтэй гэж үзэж байна"	128/ ШШ2021/0414 2021.06.10	Шүүх хуралдаанд иргэдийг төлөөлж оролцсон иргэдийн төлөөлөгч нэхэмжлэлийн шаардлагыг хангах үндэслэлтэй хэмээн дүгнэлт гаргасныг шийдвэр гаргахдаа харгалзсан болно.
5	"Т" ХХК-ийн эзэмшлийн XV-017830 тоот тусгай зөвшөөрлийн 2018 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлахгүй байгаа Увс аймгийн Өндөрхангай сумын Засаг даргын эс үйлдэхүй хууль бус болохыг тогтоож, "Т" ХХК-ийн эзэмшлийн XV-017830 тоот тусгай зөвшөөрлийн 2018 оны байгаль орчны менежментийг төлөвлөгөөг батлахыг даалгах	"Т" ХХК	Увс аймгийн Өндөрхангай сумын Засаг дарга	орсон нэр нь байхгүй	Нэхэмжлэгч "Т" ХХК-ийн нэхэмжлэлтэй, Увс аймгийн Өндөрхангай сумын Засаг даргад холбогдох захиргааны хэрэгт иргэдийн төлөөлөгчөөр оролцож дүгнэлт гаргаж байна. Нэхэмжлэгч "Т" ХХК-ийн нэхэмжлэл үндэслэлгүй, хариуцагчийн тайлбар үндэслэлтэй гэж үзэж байна	110/ ШШ2021/0044 2021.06.15	Шүүх хуралдаанд иргэдийг төлөөлж оролцсон иргэдийн төлөөлөгч нэхэмжлэлийн шаардлагыг хангах үндэслэлтэй гэсэн дүгнэлтийн Шүүхийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.7-д зааснаар шүүх харгалзан үзээд дээх хууль зүйн үндэслэлүүдээр нэхэмжлэлийн шаардлагыг хангах боломжгүй гэж үзэж байна.

6	Өмнөговь аймгийн Засаг даргын 2017 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн А/1311 дүгээр захирамжийн АНЗАОТ ХХК-д холбогдох хэсэг, Ханбогд сумын Засаг даргын 2018 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн А/24 дүгээр захирамжийн ХХК-д холбогдох хэсгийн АНЗАОТ ХХК-ийн газартай давхцаж буй 8 га газрыг тус тус хүчингүй болгуулах	АНЗАОТ ХХК	Өмнөговь аймгийн Засаг дарга	В.Мөнхнаран	Хэргийн талаар бол 2 компанийн газрын маргаан юм байна. АНЗАОТ ХХК нь газар эзэмших эрхээ 15 жилээр авсан байна. 5 жилийн дараа өөр компанид тухайн газрыг олгосноор 2 компанийн газрын маргаан үүссэн байна. Миний хувьд аль нэг компанийг буруутай гэж хэлж сайн мэдэхгүй байна. Газрын тухай хуулийн зүйл заалтыг нь би мэдэхгүй учраас компаниудыг сонсохоор нэг компанийн ярихыг сонсохоор зөв ч юм шиг, нөгөө компанийн талаар ярихаар бас зөв ч юм шиг, мөн газрын мэргэжилтэн хариуцагч ярихаар бас зөв ч юм шиг болоод байна. Хуулийнхаа дагуу л шийдэгдэх асуудал байна. Миний хувьд хуулийг сайн мэдэхгүй учраас энэ компанийн зөв юм байна гэж дүгнэлт гаргаж чадахгүй байна. Хамгийн анх 15 жилийн хугацаатай 10 га газрыг олгочихоод дундаас нь өөр компанид шилжүүлж олгоод байгаа нь буруу гэж үзэж байна гэв.	120/ ШШ2021/0008 2021.06.18	Үгүй
---	---	------------	------------------------------	-------------	--	-----------------------------	------

7	"Хан-Уул дүүргийн Татварын хэлтсийн хяналт шалгалтын тасгийн татварын улсын байцаагч О.Болдбаатар, Ц.Цэвэлмаа, Ч.Энхтуяа нарын 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 232201790 дугаар шийтгэлийн хуудсыг хүчингүй болгуулах"	"у" ХХК	Хан-Уул дүүргийн Татварын хэлтсийн хяналт шалгалтын татварын улсын байцаагч О.Болдбаатар, Ц.Цэвэлмаа, Ч.Энхтуяа	Б.Батбаатар	Үгүй	128/ ШШ2021/0460 2021.07.06	Үгүй
8	Мэргэжлийн хяналтын газрын Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагчийн 2020 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн 22-01-001/05 дугаар актыг хүчингүй болгуулах	Б.Г	ХА МХГ	Ц.Э	"Цалингийн зөрүүг олгох нь зөв" гэв	17 2021.07.19	зУШүүх хуралдаанд оролцсон иргэдийн төлөөлөгч Ц.Э "Цалингийн зөрүүг олгох нь зөв" гэсэн дүгнэлтээ Автотээврийн үндэсний төв ТӨҮГ, Хэнтий аймгийн АТТ-ийн аль нь буруутай талаар дурдаагүй нь учир дутагдалтай боллоо гэж шүүх дүгнэв.
9	Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2015 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн А/225 дугаар захирамжийн Д.Э-т холбогдох хэсгийг хүчингүй болгуулах	Д.Э	Сүхбаатар дүүргийн Засаг дарга	Д.О	"Д.Э" нэхэмжлэлтэй, Сүхбаатар дүүргийн Засаг даргад холбогдох захираганы хэрэгт дараах зүйлийг танилцаж гуравдагч этгээдийн талд шийдвэрлэж өгнө үү	128/ ШШ2021/0590 2021.09.15	Иргэдийн төлөөлөгч Д.Одончимэг нь "... Д.Эрдэнэчимэгийн нэхэмжлэлтэй, Сүхбаатар дүүргийн Засаг даргад холбогдох захираганы хэрэгт "... гуравдагч этгээдийн талд шийдвэрлэж өгнө үү" гэж дүгнэлт гаргасан ба яагаад ийнхүү дүгнэх болсон үндэслэлээ тайлбарлаагүй байна. Дээрх иргэдийн төлөөлөгчдийн дүгнэлт нь үндэслэлээ тайлбарлаагүй боловч шүүхийн энэхүү шийдвэртэй агуулгын хувьд адил байна.

10	"ОР-217/2020 дугаартай Орхон аймаг дахь орон сууцны 1А хорооллын дэд бүтэц барих тендерт ирүүлсэн "Б" ХХК-ийн тендерээс татгалзсан ОАЗДТГ-ын 2020 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 03/1265 тоот мэдэгдэл хууль бус байсан болохыг тогтоож, хүчингүй болгож, "Х" ХХК-ийн ирүүлсэн тендерийг хамгийн сайн гэж үнэлж, гэрээ байгуулах эрх олгосон мэдэгдлийг хүчингүй болгон, нэхэмжлэгчтэй гэрээ байгуулахыг ОАЗДТГ-т даалгах"	"Б" ХХК	ОАЗДТГ	Д.Н	"Ижил төстэй үйл ажиллагаатай байгууллагууд хамтдаа буюу хамтраад бүтээн байгуулалтыг гүйцэтгэж болох болов уу" гэв.	14 2021.06.08	Үгүй
11	Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн А/751 дүгээр тушаалыг хүчингүй болгуулах	О.О	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд	Ө.Доржханд	"...нэхэмжлэлийн шаардлагыг дэмжихгүй" гэв.	128/ шш2021/0350 2021.05.20	Шүүх хуралдаанд оролцсон Иргэдийн төлөөлөгчөөс "... нэхэмжлэлийн шаардлагыг дэмжихгүй" гэсэн дүгнэлт гаргасан бөгөөд энэ шүүхийн шийдвэрээр нэхэмжлэгчийн гаргасан нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон тул уг шийдвэрийн үндэслэлүүдээр Иргэдийн төлөөлөгчийн дүгнэлт хангагдсан болохыг дурдаж байна.
12	Чингэлтэй дүүргийн Татварын хэлтсийн татварын улсын байцаагчийн 2017 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 351730071 тоот шийтгэлийн хуудсыг хүчингүй болгуулах	гомдол гаргагч "Монтрак групп" ххк	Чингэлтэй дүүргийн Татварын хэлтсийн татварын улсын байцаагч Б.Цэвэлмаа, Б.Бат-Эрдэнэ	Н.Сарангэрэл	2011 оноос 2013 оны татварын төлөлтийн талаар маргаж байна. Өршөөлийн хуулиар өршөөгдсөн байна. Мэтгэлцээний явцад хариуцагч прокурорын гаргасан дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөн байна. гэв.	128/ шш2021/0344 2021.05.20	Үгүй

13	эрчим хүчний хяналтын улсын байцаагчийн 2020 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн 0067114 дүгээр шийтгэлийн хуудсыг хүчингүй болгуулах,	"... ГҮТББ	Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Дэд бүтцийн хэлтсийн эрчим хүчний хяналтын улсын байцаагч*****	*****	Нийслэлийн Мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн шийтгэлийн хуудсыг үндэслэлтэй гэж үзэж байна	128/ ШШ2021/0332 2021.05.19	Шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгч нь улсын байцаагчийн шийтгэлийн хуудсыг үндэслэлтэй гэж үзэж буйгаа дүгнэжээ.
14	Нийслэлийн Татварын газрын даргын 2019 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн Д.Батжаргалыг албан тушаалд томилох тухай Б/32 дугаар тушаалыг хүчингүй болгуулах. Хан-Уул дүүргийн Татварын хэлтсийн даргын албан тушаалд Г.Сүрэнтамжид намайг томилохгүй байгаа эс үйлдэхүй хууль бус болохыг тогтоож, томилохыг Татварын ерөнхий газрын даргад даалгах, Татварын ерөнхий газрын даргын 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн А/20 дугаар тушаалаар ногдуулсан сахилгын шийтгэлийг хүчингүй болгуулах	Аргай овогт Гунгаагийн Сүрэнтам-жид	Татварын ерөнхий газрын дарга, Нийслэлийн Татварын газрын дарга,	Д.Энхжаргал	Нэхэмжлэлийн талаар гаргасан дүгнэлтээ: Нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлагыг дэмжиж байна	128/ ШШ2021/0330 2021.05.18	Иргэдийн төлөөлөгчийн хувьд нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлагыг хангах нь зүйтэй гэсэн дүгнэлт гаргасан боловч дээрх үндэслэлүүдээр нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хүлээн авахаас татгалзаж, үлдэх хэсгийг хэрэгсэхгүй болгох нь зүйтэй гэж шүүх бүрэлдэхүүн үзсэн болно.
15	"Нийслэлийн Засаг даргын 2017 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн "Тусгай зөвшөөрлийг цуцалж, газрын хэвлий ашиглах эрхийг дуусгавар болгох тухай" А/609 дүгээр захирамжийн "С" ХХК-д холбогдох хэсгийг хүчингүй болгож, тус компанийн зээмшлийн МУ-017341 дугаар бүхий ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийг сэргээхийг Нийслэлийн Засаг даргад даалгуулах"	"С" ХХК	Нийслэлийн Засаг дарга	Ү.Н	"...Хоёр талаас актын талаар санал нийлэхгүй байна. Нэхэмжлэлийн шаардлагыг дэмжиж байна." гэв.	128/ ШШ2021/0313 2021.05.14	Шүүх хуралдаанд оролцсон иргэдийн төлөөлөгчөөс "... нэхэмжлэлийн шаардлагыг дэмжиж байна" гэсэн дүгнэлт гаргасан боловч шүүх дээр дурдсан хууль зүйн үндэслэлүүдээр уг дүгнэлтийг хүлээж аваагүй болно.

16	Ашигт малтмалын хайгуулын XV-009177 дугаар тусгай зөвшөөрлийн хугацаа дуусгавар болсныг кадастрын бүртгэлийн санд бүртгэсэн 2019 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн бүртгэлийг хүчингүй болгож, XV-009177 дугаар тусгай зөвшөөрлийн талбайд "Э.У" ХХК -ийн гаргасан ашиглалтын тухай зөвшөөрөл олгохыг хүссэн хүсэлтийг холбогдох материалын хамт хүлээн авч, хуулийн дагуу шийдвэрлэхийг Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын хэлтэст даалгуулах	"Э.У" ХХК	Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын хэлтсийн дарга	Ц.Л	"Нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэх нь зүйтэй байна. Яагаад гэвэл нэхэмжлэгч нь ямар нэг байдлаар өргөдөл гаргаж, ашиглалтын тусгай зөвшөөрөл авахыг хүссэн нь нотлогдохгүй байна" гэжээ.	128/ ШШ2021/0307 2021.05.13	Иргэдийн төлөөлөгч дүгнэлтдээ "Нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэх нь зүйтэй байна. Яагаад гэвэл нэхэмжлэгч нь ямар нэг байдлаар өргөдөл гаргаж, ашиглалтын тусгай зөвшөөрөл авахыг хүссэн нь нотлогдохгүй байна" гэсэн бөгөөд иргэдийн төлөөлөгчийн дүгнэлт үндэслэлтэй болох нь шүүхийн дээрх дүгнэлтээр тогтоогдож байна.
17	Х.А, 3.Х нарт газар эзэмшүүлсэн СБДЗД-ын 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А/543 дугаар захирамжийг хүчингүй болгуулах	Г.Б, Г.Х	Сүхбаатар дүүргийн Засаг дарга	Т.Д		128/ ШШ2021/0290 2021.05.11	Үгүй
18	Улсын бүртгэлийн ерөнхий газрын хяналтын улсын байцаагчийн 2019 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн Улсын бүртгэлийг түдгэлзүүлэх тухай 705 дугаартай дүгнэлтийн эрхийн улсын бүртгэлийн У-2003021859, У-2003021860 дугаартай бүртгэлд холбогдох хэсгийг хүчингүй болгуулах	Дөлгөөн	Улсын бүртгэлийн ерөнхий газрын хяналтын улсын байцаагч Б.Ганзориг,	Л.Л, Н.У / цахимаар/	Иргэдийн төлөөлөгч Н.Уранбилэг дүгнэлтдээ: Хяналтын улсын байцаагчийн дүгнэлт үндэслэлтэй гарсан байна. гэв. Иргэдийн төлөөлөгч Л.Лутбилэг дүгнэлтдээ: Мөн адил хяналтын улсын байцаагчийн дүгнэлт үндэслэлтэй гарсан байна.	128/ ШШ2021/0247 2021.03.31	Үгүй

19	Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын хэлтсийн даргын 2018 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 361 дугаартай Эй Би Пи девелопмент ХХК-ийн Увс аймгийн Өндөрхангай, Зүүнхангай сумдыг дамнасан Хангай нэртэй XV-018330 тоот хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацааг сунгаахаас татгалзах тухай шийдвэр. Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын хэлтсийн даргын 2018 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 488 дугаартай Увс аймгийн Өндөрхангай сумын Баавгай нэртэй XV-018799 тоот хайгуулын тусгай зөвшөөрлүүдийн хугацааг сунгаахаас татгалзах тухай шийдвэрийг тус тус хүчингүй болгож, XV-018330, XV-018799 тоот хайгуулын тусгай зөвшөөрлүүдийн эрхийг сэргээж, хугацааг 4 дэх жилээс эхлэн тооцож өгөхийг Ашигт малтмал, газрын тосны газарт даалгах	"Эй Би Пи девелопмент" ХХК	Ашигт малтмал, газрын тосны газар, тус газрын Геологи, уул уурхайн кадастрын хэлтэс	Ц.Насантогтох	...Нэхэмжлэлийн шаардлага нь зөв гэсэн итгэл үнэмшил төрж байна. гэв.	128/ШШ2021/0219 2021 03 24	Мөн иргэдийн төлөөлөгчөөс нэхэмжлэлийн шаардлага нь зөв гэсэн дүгнэлт гаргасан болохыг дурдах нь зүйтэй байна.
----	---	----------------------------	---	---------------	---	-------------------------------	--

20	Дорнод аймгийн Засаг даргын 2019 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн А/482 дугаар захирамжийг хүчингүй болгуулах	К ХХК дахь Банкны эрх хүлээн авагч	Дорнод аймгийн Засаг дарга	Г.У	К банк ХХК дахь Банкны эрх хүлээн авагчийн нэхэмжлэлтэй Дорнод аймгийн Засаг даргад холбогдох захиргааны хэрэгт дараах дүгнэлтийг гаргаж байна. Газрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 40 дүгээр зүйлийн 40.1.5, 40.1.6-д зааснаар газрын төлбөрөө хугацаанд нь төлөөгүй, хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гэрээнд заасан зориулалтын дагуу тухайн газрыг 2 жил дараалан ашиглаагүй байна. Татан буудсан К нь Газрын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.3 дахь заалтыг биелүүлээгүй байна. Иймд Дорнод аймгийн Засаг даргын 2019 оны 09 сарын 18-ны өдрийн А/482 дугаар захирамжаар газар эзэмших эрхийг хүчингүй болгох нь зөв гэсэн дүгнэлт нь хэрэгт авагдсан бичгийн нотлох баримтаар давхар нотлогдож байх тул иргэдийн төлөөлөгчийн дүгнэлт үндэслэлтэй байна.	116/ ШШ2021/0005 2021.03.23	Иргэдийн төлөөлөгч Г.Уийн шүүх хуралдаанд гаргасан Газрын тухай хуулийн 40.1.6-д зааснаар хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гэрээнд заасан зориулалтын дагуу тухайн газрыг 2 жил дараалан ашиглаагүй байна. Татан буудсан К нь Газрын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.3 дахь заалтыг биелүүлээгүй байна. Иймд Дорнод аймгийн Засаг даргын 2019 оны 09 сарын 18-ны өдрийн А/482 дугаар захирамжаар газар эзэмших эрхийг хүчингүй болгох нь зөв гэсэн дүгнэлт нь хэрэгт авагдсан бичгийн нотлох баримтаар давхар нотлогдож байх тул иргэдийн төлөөлөгчийн дүгнэлт үндэслэлтэй байна.
----	---	------------------------------------	----------------------------	-----	--	-----------------------------------	--

21	Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны 01 дугаар сарын 18-ны өдрийн Б/176 дугаар тушаалын 1 дэх заалтын Б.Нансалмааг 2019 оны 1 дүгээр сарын 16-ны өдрөөр албан тушаалаас нь чөлөөлж, Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төвийн мэдэлд шилжүүлсэн хэсгийг хүчингүй болгуулах, 2019 оны 01 дүгээр сарын 16-ны өдрөөс шүүхийн шийдвэр гарах хүртэл ажилгүй байсан хугацааны цалин, зөрүүг гаргуулах	Нансалмаа	Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга	Л.Ц	Үгүй	Үгүй	
22	Захиргааны ерөнхий хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэгт зааснаар НЗД-ын 2017 оны 8 дугаар сарын 21-ний өдрийн А/609 дүгээр захирамжийн "Э.Б" ХХК-д холбогдох хэсгийг хүчингүй болгуулах	"Э.Б" ХХК	Нийслэлийн Засаг дарга	Д.Н	"Нэхэмжлэгч талын хөөн хэлэлцэх хугацаа дууссан. 3 жилийн хугацаандаа ашиглаагүй тул шаардлага хангаагүй байна" гэв	128/ШШ2021/0162 2021.03.09	Үгүй
23	Сүхбаатар аймгийн ЗД-ын 2020 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн .. дугаар захирамжийг хууль бус байсан болохыг тогтоолж, албан тушаалын цалингийн зөрүү гаргуулах	У.Б	Сүхбаатар дүүргийн Засаг дарга	А.Н	Нэхэмжлэгч У.Б-ийн нэхэмжлэл үндэслэлтэй байна гэж үзлээ гэв.	09 2021.03.04	Хэрэг маргааныг анхан шатны журмаар шүүх бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгч оролцож, хэргийн үйл баримтад үнэлэлт өгч, дүгнэлт гаргах бөгөөд У.Б-ийн нэхэмжлэлтэй, Сүхбаатар аймгийн ЗД-д холбогдох хэргийн шүүх хуралдаанд оролцсон иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийг үндэслэл бүхий байна гэж шүүх бүрэлдэхүүн дүгнэв.

24	Нийслэлийн газар зохион байгуулалтын алба газрын тухай хуулиа зөрчиж, газар эзэмших эрхийг давхцуулсан үйл ажиллагаа хууль бус болохыг тогтоож, давхцалыг арилгах арга хэмжээ авч шийдвэрлэхийг даалгах тухай	"Нью стандарт ложистик" ХХК	Нийслэлийн газар зохион байгуулалтын алба	...	Ба "..."	128/ ШШ2021/0107 2021.02.05	Үгүй
25	Татварын ерөнхий газрын Улсын төсвийн орлого, хяналтын газрын татварын улсын байцаагч Ж.Нансалмаа, Ж.Эрдэнэтуул нарын 2017 оны 9 дүгээр сарын 23-ны өдрийн хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн 0300314 тоот шийтгэлийн хуудсыг бүхэлд нь хүчингүй болгуулах	"Трансвест монголиа" ХХК	Татварын ерөнхий газрын Улсын төсвийн орлого, хяналтын газрын татварын улсын байцаагч Ж.Эрдэнэтуул	Д.Сарантуяа	Үгүй	128/ ШШ2021/0100 2021.02.03	Үгүй
26	Завхан аймгийн Эрдэнэхайрхан сумын Засаг даргын 12596Х дугаартай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн хүрээнд хийгдсэн хайгуулын ажлын явцад байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу хүлээсэн үүргийг бүрэн биелүүлж ажилласан тухай тодорхойлолтыг гаргаж өгөхөөс татгалзсан хариу хууль бус болохыг тогтоож, Ашигт малтмалын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.6 дах хэсэгт заасан тодорхойлолтыг Ш Ж ЧХХК-д гаргаж өгөхийг даалгах	Ш Ж ЧХХК	Завхан аймгийн Эрдэнэхайрхан сумын Засаг дарга	Г.Батгэрэл	Ш Ж ЧХХК-ийн буруу, Эрдэнэхайрхан сумын Засаг даргад шаардлагатай бичиг, тайланг бүрдүүлж өгөх шаардлагатай гэж үзэж байна.	112/ шш2021/0003 2021.02.02	Үгүй

27	Засгийн газрын 2019 оны 51 дүгээр тогтоолыг хүчингүй болгуулах тухай	Ч.Д нар	Монгол Улсын Засгийн газар	Ч.Ш	"Нэхэмжлэгчиргэний нэхэмжлэлтэй, МУЗГТ холбогдох захиргааны хэрэгтэй танилцсан ба шүүх хуралдаанаар хэлэлцүүлтийг сонсоод хариуцагчийн ярьж, тайлбарлаж байгааг үндэслэлтэй гэж үзэж байна. Энэ байдлыг шүүх харгалзан үзнэ үү"	128/ШШ2021/0092 2021.02.02	дурдсан
----	--	---------	----------------------------	-----	---	-------------------------------	---------

ХЗҮХ